



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/21

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.1.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.3, Засгийн газрын 2016 оны 09 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэх ажлын хүрээнд “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Бат-Октябрь	-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ж.Ганбаяр	-Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
Ажлын хэсгийн гишүүд:	Ж.Гантулга	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Д.Сарангэрэл	-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хууль, эрх зүйн асуудал хариуцсан ажилтан
	Б.Баярсайхан	-Цагдаагийн газрын Нийгмийн хэв журам хамгаалах тасгийн дарга
	Д.Эрдэнэбаясгалан	-Хүний эрхийн үндэсний комиссын Хэнтий аймаг дахь ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	О.Ганбаатар	-Улсын бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагч
	Х.Уртнасан	-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн
	П. Батжаргал	-Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Захиргаа хяналтын хэлтсийн дарга

2//.

Д.Жаргалмаа	-Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
Д.Уламбаяр	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
А.Золзаяа	-Эрүүл мэндийн газрын мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
Л.Үл-Олдох	-Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл /зөвшилцсөнөөр/

2. "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг төлөвлөн, батлуулж, тус төлөвлөгөөнд үндэслэн тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллахыг ажлын хэсэг /Л.Бат-Октябрь/-т даалгасугай.

3. "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, ажлын явцыг танилцуулж байхыг ажлын хэсэг /Л.Бат-Октябрь/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР